

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/07/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ТӨВИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор :Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.10 № 01/37
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БОЛДБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн тасгийн албан хаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарыг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар ханган, мал эмнэлгийн нэгдсэн 5 төрлийн үйлчилгээг малчдад үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг цахимаар харах боломжтой болгон "Иргэн төв төрийн үйлчилгээ"-г нэвтрүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторов мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Малын халдварт өвчний үйлчилгээний хөлсний үлдэгдэл санхүүжилтийг Сангийн яамнаас дараа онд олгохоор шийдвэрлэсэнтэй холбоотойгоор өглөг 105,151.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Тус байгууллага өмнөх онд 218,595.5 мянган төгрөгийн давхар орлого авсан мал угаалгын ванныг данснаас хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,995,876.46	84,459,621.05
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	113,795,876.46	84,459,621.05
35100	Түүхий эд материал	97,983,911.46	69,881,954.05
35110	Тусгай зориулалттай материал	82,456,724.00	69,881,954.05
35130	Эм боох материал	15,527,187.46	0
35400	Хангамжийн материал	15,811,965.00	14,577,667.00
35410	Бичиг хэргийн материал	5,566,015.00	4,149,230.00
35420	Аж ахуйн материал	2,174,150.00	3,358,437.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,324,300.00	3,744,300.00
35440	Түлш, шатах тослох материал	5,774,000.00	2,082,200.00
35450	Барилгын засварын материал	81,500.00	71,500.00
35470	Бусад хангамжийн материал	892,000.00	1,172,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,201,694,707.52	979,514,043.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,201,694,707.52	979,514,043.75
39200	Биет хөрөнгө	1,144,941,707.71	923,333,043.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	554,372,793.16	554,372,793.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,595,543.42	-49,554,466.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,634,124.15	222,634,124.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,544,349.90	-120,858,803.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,356,068,513.55	1,180,819,677.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-889,779,328.90	-884,643,612.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,919,597.34	45,162,597.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,134,098.27	-24,599,265.63
39300	Биет бус хөрөнгө	56,752,999.81	56,180,999.77
39301	Програм хангамж	2,860,000.00	2,860,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,232,000.19	-1,804,000.23
39303	Бусад биет бус хөрөнгө	55,125,000.00	55,125,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,322,690,583.98	1,063,973,664.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	105,151,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	105,151,800.00
41300	Өглөг	0	105,151,800.00
41360	Бусад өглөг	0	105,151,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	105,151,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,322,690,583.98	958,821,864.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,322,690,583.98	958,821,864.80
51200	Хуримтлагдсан үр дүн	1,322,690,583.98	958,821,864.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,607,307,222.97	1,265,309,250.04
51220	Тайлант үеийн үр дүн	-284,616,638.99	-306,487,385.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,322,690,583.98	1,063,973,664.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,041,401,813.35	3,228,485,182.80		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,124,154,782.75	1,213,120,032.80		
120	Нийтлэг татварын бус орлого	2,124,154,782.75	1,213,120,032.80		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,000.00	1,065,000.00		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000.00	1,065,000.00		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,864,850.00	38,374,719.88		
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,105,204,932.75	1,173,680,312.92		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,917,247,030.60	2,015,365,150.00		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,341,152,000.00	1,564,275,000.00		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,341,152,000.00	1,564,275,000.00		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	576,095,030.60	451,090,150.00		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00	1,280,000.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	571,500,290.00	449,810,150.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	263,740.60	0		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,326,018,452.34	3,534,972,568.04		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,326,018,452.34	3,534,972,568.04		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,237,452,728.24	3,459,423,139.18		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,630,168.70	822,752,462.41		
210101	Үндсэн цалин	553,790,083.66	614,508,718.84		
210102	Нэмэгдэл	125,919,120.53	118,676,648.39		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,037,700.00	59,978,808.59		
210104	Урамшуулал	19,883,264.51	29,588,286.59		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,271,461.05	102,617,297.33		
210201	Тэтгэврийн даатгал	66,771,150.08	70,329,703.00		
210202	Тэтгэмжийн даатгал	7,493,514.30	8,228,050.94		
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,942,813.45	6,555,440.50		
210204	Ажилгүйдлийн даатгал	1,414,694.64	1,591,399.19		
210205	Эрүүл мэндийн даатгал	14,649,288.58	15,912,703.70		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,661,297.75	20,567,417.40		
210301	Гэрэл, цахилгаан	5,305,842.00	5,983,121.02		
210302	Түлш, халаалт	13,392,359.75	13,598,490.38		
210303	Цэвэр, бохир ус	963,096.00	985,806.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	40,788,361.36	42,619,884.38		
210401	Бичиг хэрэг	6,849,895.00	5,943,635.00		
210402	Тээвэр, шатахуун	20,730,600.00	24,313,800.00		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,381,043.00	2,673,076.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	240,000.00		

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,383,500.00	1,163,000.00
210408	Бараа материал акталсны зардал	7,443,323.36	0
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0	8,286,373.38
2105	Нормативт зардал	2,099,518,343.71	1,162,599,490.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,099,518,343.71	1,159,885,140.70
210502	Хоол, хүнс	0	2,714,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,242,760.00	2,348,680.00
210604	Урсгал засвар	5,242,760.00	2,348,680.00
2107	Томилолт, зочны зардал	20,578,000.00	15,052,000.00
210702	Дотоод албан томилолт	20,578,000.00	15,052,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	890,772,436.00	1,013,926,451.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	884,412,350.00	1,009,215,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	420,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,567,000.00	3,247,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	331,086.00	278,501.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	87,000.00	73,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	275,000.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	331,989,899.67	276,939,455.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,321,565.75	67,550,406.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,090.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	285,462,243.92	209,389,049.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,565,724.10	75,549,428.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	539,200.00	34,188,969.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	150,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	32,479,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	539,200.00	1,559,569.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,026,524.10	41,360,459.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,192,943.50	37,895,159.86
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	833,580.60	3,465,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-284,616,638.99	-306,487,385.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-284,616,638.99	-306,487,385.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,917,332,030.60	2,016,430,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,000.00	1,065,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,000.00	1,065,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,000.00	1,065,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000.00	1,065,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,917,247,030.60	2,015,365,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,341,152,000.00	1,564,275,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,341,152,000.00	1,564,275,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	576,095,030.60	451,090,150.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00	1,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	571,500,290.00	449,810,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	263,740.60	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,909,969,030.60	2,010,215,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,909,969,030.60	2,010,215,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,821,403,306.50	1,931,271,321.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,630,168.70	822,752,462.41
210101	Үндсэн цалин	553,816,583.66	616,121,828.87
210102	Нэмэгдэл	125,919,120.53	118,559,320.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,011,200.00	59,599,589.79
210104	Урамшуулал	19,883,264.51	28,471,722.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,271,461.05	102,617,297.33
210201	Тэтгэврийн даатгал	66,833,555.48	70,329,703.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,512,763.07	8,228,050.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,861,160.00	6,555,440.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,414,694.64	1,591,399.19
210205	Эрүүл мэндийн даатгал	14,649,287.86	15,912,703.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,741,297.75	21,107,417.40
210301	Гэрэл, цахилгаан	5,305,842.00	5,983,121.02
210302	Түлш, халаалт	14,472,359.75	13,988,490.38
210303	Цэвэр, бохир ус	963,096.00	1,135,806.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,425,083.00	29,134,076.00
210401	Бичиг хэрэг	6,986,650.00	4,372,650.00
210402	Тээвэр, шатахуун	23,064,600.00	20,082,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,447,543.00	2,681,476.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	926,290.00	1,757,950.00
2105	Нормативт зардал	1,937,060.00	20,076,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	520,000.00	18,895,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,417,060.00	1,181,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,427,140.00	11,756,817.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,450.00	49,500.00
210604	Урсгал засвар	7,306,690.00	11,707,317.00
2107	Томилолт, зочны зардал	20,578,000.00	15,052,000.00
210702	Дотоод албан томилолт	20,578,000.00	15,052,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	903,493,946.00	908,774,651.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	889,933,860.00	904,064,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	420,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,567,000.00	3,247,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	331,086.00	278,501.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	87,000.00	73,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	275,000.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,899,150.00	0

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,693,060.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,090.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,565,724.10	78,943,828.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	539,200.00	37,583,369.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	2,630,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	32,479,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	539,200.00	2,473,969.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,026,524.10	41,360,459.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,192,943.50	37,895,159.86
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	833,580.60	3,465,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,363,000.00	6,215,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,363,000.00	6,215,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,363,000.00	6,215,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,363,000.00	6,215,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,363,000.00	6,215,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,363,000.00	-6,215,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	1,607,307,222.97	1,607,307,222.97
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	1,607,307,222.97	1,607,307,222.97
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-284,616,638.99	-284,616,638.99
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	1,322,690,583.98	1,322,690,583.98
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	1,322,690,583.98	1,322,690,583.98
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-57,381,333.94	-57,381,333.94
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	1,265,309,250.04	1,265,309,250.04
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-306,487,385.24	-306,487,385.24
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	958,821,864.80	958,821,864.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,570,275,000.00	1,527,444,840.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,570,275,000.00	1,527,444,840.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,532,256,400.00	1,489,861,471.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	858,506,900.00	822,752,462.41
210101	Үндсэн цалин	621,524,700.00	616,121,828.87
210102	Нэмэгдэл	141,384,600.00	118,559,320.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,220,700.00	59,599,589.79
210104	Урамшуулал	33,376,900.00	28,471,722.99
210105	Гэрээт ажлын хөлс	0	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,138,500.00	102,617,297.33
210201	Тэтгэврийн даатгал	72,174,100.00	70,329,703.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,491,100.00	8,228,050.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,792,900.00	6,555,440.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,698,300.00	1,591,399.19
210205	Эрүүл мэндийн даатгал	16,982,100.00	15,912,703.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,728,700.00	21,107,417.40
210301	Гэрэл, цахилгаан	6,081,800.00	5,983,121.02
210302	Түлш, халаалт	16,505,100.00	13,988,490.38
210303	Цэвэр, бохир ус	1,141,800.00	1,135,806.00
210304	Байрны түрээс	0	0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,110,700.00	23,019,076.00
210401	Бичиг хэрэг	4,380,600.00	4,372,650.00
210402	Тээвэр, шатахуун	14,046,600.00	13,967,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,682,900.00	2,681,476.00
210404	Ном, хэвлэл	0	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,760,600.00	1,757,950.00
2105	Нормативт зардал	20,093,800.00	20,076,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,906,900.00	18,895,000.00
210502	Хоол, хүнс	0	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,186,900.00	1,181,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,088,600.00	17,971,817.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,307,600.00	6,264,500.00
210604	Урсгал засвар	11,781,000.00	11,707,317.00
2107	Томилолт, зочны зардал	5,075,800.00	5,062,500.00
210702	Дотоод албан томилолт	5,075,800.00	5,062,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	477,473,300.00	477,254,301.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	472,679,200.00	472,543,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,200.00	420,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,317,500.00	3,247,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,200.00	278,501.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,900.00	73,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	151,300.00	151,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,100.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,100.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,018,600.00	37,583,369.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,018,600.00	37,583,369.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,630,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,479,400.00	32,479,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,539,200.00	2,473,969.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,570,275,000.00	1,527,444,840.14
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,564,275,000.00	1,526,379,840.14
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,564,275,000.00	1,526,379,840.14
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000,000.00	1,065,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	1,065,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82	64
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	79	44
620003	Үйлчлэх ажилтан	2	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	62	0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,261,450.00	447,624,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,261,450.00	447,624,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,261,450.00	447,624,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,985,600.00	6,115,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,985,600.00	6,115,000.00
2107	Томилолт, зочны зардал	16,392,500.00	9,989,500.00
210702	Дотоод албан томилолт	16,392,500.00	9,989,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550,883,350.00	431,520,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,883,350.00	431,520,350.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	833,580.00	3,465,300.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	833,580.00	3,465,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	576,095,030.00	451,090,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	576,095,030.00	451,090,150.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00	1,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	571,500,290.00	449,810,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	263,740.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь тайлант онд 81 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулахаар бүтэц орон тоо батлагдсанаас удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх 44, үйлчлэх 19 нийт 64 орон тоогоор үйл ажиллагаа явуулж 17 орон тоо дутуу ажилласан байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг, Мал Эмнэлгийн Ерөнхий Газрын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн тасгийн албан хаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарыг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар ханган, мал эмнэлгийн нэгдсэн 5 төрлийн үйлчилгээг малчдад үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг цахимаар харах боломжтой болгон "Иргэн төв төрийн үйлчилгээ"-г нэвтрүүлж ажилласан байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 16 зорилт, хэрэгжүүлэх 74 арга хэмжээтэй баталснаас нийт 91,4%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Дотоод хяналт, шалгалтын комиссыг шинэчлэн батлах тухай" А/01 тушаал, 6 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 20-21 арга хэмжээг улирлаар төлөвлөн захиргаа, төсөв санхүү, мал эмнэлгийн лаборатори, мал амьтны эрүүл мэндийн албаны үйл ажиллагаанд хийж 4 чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд Мал эмнэлгийн ерөнхий газар болон аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн №А/385 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн салбарын бүртгэл тайлагналын онцлог гэсэн 11 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 258,717.0 мянган төгрөгөөр буюу 19,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Урьдчилгаа	7,200.0	0	-7,200.0
Авлага	0	0	0
Бараа материал	113,795.8	84,459.6	-29,336.2
Үндсэн хөрөнгө	1,201,694.7	979,514.0	-222,180.7
Нийт хөрөнгө	1,322,690.6	1,063,973.6	-258,717.0
Өр төлбөр		105,151.8	105,151.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,322,690.6	958,821.8	-363,868.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,322,690.6	1,063,973.6	-258,717.0

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 113,795.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 84,459.6 мянган төгрөг буюу зарцуулсан болон шилжүүлсэн хөрөнгө 29,336.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,201,694.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 979,514.0 мянган төгрөг болж, 222,180.7 мянган төгрөгөөр буурсан нь 218,595.5 мянган төгрөгийн давхар орлого авсан мал угаалгын ванныг данснаас хассантай холбоотой байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 6,215.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 1,243.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 37,131.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 105,151.9 мянган төгрөг болж 105,151.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь халдварт өвчний үйлчилгээний хөлсний үлдэгдэл санхүүжилтийг Сангийн яамнаас шийдэж өгөөгүй, дараа онд олгохоор шийдвэрлэсэнтэй

холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 958,821.8 мянган төгрөг болж 363,868.8 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,069,745.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулахгүйгээр 1,069,745.9 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна. Тус байгууллагын төсвийг Мал эмнэлгийн ерөнхий газраас 3 удаа тодотгон 1,564,275.0 мянган төгрөгөөр ирүүлсэн байна. Энэ нь мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн малын халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний зардлыг 252,500.0 мянган төгрөг, малын архаг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний зардлыг 219,900.0 мянган төгрөг, мал амьтны халдваргүйжүүлэх арга хэмжээний зардлыг 17,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн дүнгээр буюу улсын төсвөөс 1,069,845.7 мянган төгрөгөөр батлан ирүүлснийг улсын төсөвт тодотгол хийсний дагуу 1,564,275.0 мянган төгрөгөөр Мал эмнэлгийн ерөнхий газраас ирүүлсэн байна. Тайлант оны батлагдсан төсвийг 494,429.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,564,275.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр нийт 1,570,275.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,564,275.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,065.0 мянган төгрөг нийт 1,565,340.0 мянган төгрөгийг бүрдүүлж 37,895.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 4,935.0 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,527,444.8 мянган төгрөг буюу 97,3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 39,275.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 2,621.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 91.6 мянган төгрөг, норматив зардал 17.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 116.8 мянган төгрөг, томилолтын зардал 13.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 259.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 435.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70801-80101	639,504.6	625,228.8	14,275.8	97.8
2	70801-80802	3,000.0	2,630.0	370.0	87.7
3	70801-82504	252,500.0	252,500.0	0	100
4	70801-82507	219,980.0	219,980.0	0	100
5	70801-82510	17,000.0	17,000.0	0	100
6	70805-80101	255,681.4	244,775.7	10,905.7	95.7
7	70805-80227	68.1	0	68.1	0
8	70805-80802	35,018.6	34,953.4	65.2	99.8
9	70806-80101	147,522.3	130,376.9	17,145.4	88.4
	Дүн	1,570,275.0	1,527,444.8	42,830.2	97.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 449,810.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1,280.0 мянган төгрөг нийт 451,090.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар тээвэр шатахуунд 6,115.0 мянган төгрөг, дотоод албан томилолт 9,989.5 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 431,520.3 мянган төгрөг нийт 447,624.8 мянган төгрөг зарцуулж, 3,465.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70801	2022.01.01-2022.12.31	Мал аж ахуйг хөгжүүлэх	Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр 98,7%	1,131,984.6	1,117,338.8
2	70805	2022.01.01-2022.12.31	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлагаар хангах	Хөдөө аж ахуй газар тариалан аж үйлдвэрийн бодлого удирдлагаар хангах хөтөлбөр 96,2%	290,768.1	279,729.1
3	70806	2022.01.01-2022.12.31	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа, шинжилгээ	Хөдөө аж ахуй газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ 88,4%	147,522.3	130,376.9

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ хөтөлбөр 88,4 хувь буюу 11,6 хувиар дутуу хэрэгжсэн нь орон тоо бүтэц 60-64 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж 17 орон тоо дутуугаас шалтгаалсан байна. Орон тоо бүтэц дутуу ажилласан нь төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамнаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2022 оны 1,532,425.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 15,324.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,949.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 97,7 хувь, 5,0 саяас дээших орлогын 51 гүйлгээ, зарлагын 29 гүйлгээ, 5,0 саяас дээших худалдан авалттай холбоотой 18 гүйлгээ хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалт цахим төлбөрийн баримттай холбоотой 1 албан шаардлага, дотоод хяналт шалгалттай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 156 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	755,999.0	1	755,999.0	100
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	2	755,999.0	2	755,999.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны А/04 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журмын” 9.4-ийн 9.4.2-дах заалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,337.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,337.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого 2,337.9 мянган төгрөгөөр бараа материалын тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дүнтэй зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 7,353.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,881.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 4,472.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүллээ.

5.2 Төлбөрийн акт

1.Тус байгууллага тайлант онд Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/76 тоот тушаалаар нэмэгдэл цалин, 2022 оны 12 дугаар сарын 01-ны Б/72 тоот тушаалаар Солонгос улсад ажиллахаар явсан Захиргаа, санхүү албаны даргад 2 сарын цалинтай чөлөө олгож 2,067.3 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2.Тус байгууллага тайлант онд төсвийн хөрөнгөөр хүнсний бараа, оо цаас болон бусад шаардлагагүй бараа материал 534.0 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-дэх заалт “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3.Тус байгууллага тайлант онд ажлын дүрэмт хувцас буюу хантааз 280.0 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд бичиг хэргийн зардлыг хэмнээгүй шаардлагагүй бичиг хэргийн материал 417.2 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Тус байгууллага тайлант онд сумдад зохион байгуулсан малчдын зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож томилолт, шатахууны зардалд 1,973.1 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3.Тус байгууллага тайлант онд 2,082.2 мянган төгрөгийн шатахууны талон нөөцөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн зөрүүтэй тайлагнасан байна.	1	2,337.9			1	2,337.9	1	2,337.9
Дүн	1	2,337.9			1	2,337.9	1	2,337.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/76 тоот тушаалаар нэмэгдэл цалин, 2022 оны 12 дугаар сарын 01-ны Б/72 тоот тушаалаар Солонгос улсад ажиллахаар явсан Захиргаа, санхүү албаны даргад 2 сарын цалинтай чөлөө олгосон	1	2,067.3	1	2,067.3				
Төсвийн хөрөнгөөр хүнсний бараа, 00 цаас болон бусад шаардлагагүй бараа материал худалдан авсан.	1	534.0	1	534.0				
Тайлант онд ажлын дүрэмт хувцас буюу хантааз худалдан авсан.	1	280.0	1	280.0				
Тайланд онд үзэг бал, штрих, зургийн цаас, өнгийн харандаа, бэлгийн уут, зургийн дэвтэр зэрэг бичиг хэргийн зардлыг хэмнээгүй шаардлагагүй зүйлс худалдан авсан.	1	417.2			1	417.2		
Сумдад зохион байгуулсан малчдын зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож томилолт, шатахууны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.	1	1,973.1			1	1,973.1		
Тайлант онд шатахууны талон зарцуулж нөөцөлсөн зөрчил илэрлээ.	1	2,082.2			1	2,082.2		
Дүн	6	7,353.8	3	2,881.3	3	4,472.5		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn